



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 4/90

Улаанбаатар хот


Эрдэм шинжилгээний уралдааны
бүтээлийг шагнах тухай

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 15¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Монгол Улсад Статистикийн алба үүсэж хөгжсөний 95 жилийн ойг угтан Үндэсний статистикийн хороо, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар хэлтсийн албан хаагчид дунд зохион байгуулсан эрдэм шинжилгээний уралдаанд “Салбар хоорондын тэнцлийн шинжилгээг байгаль орчны үзүүлэлтээр өргөтгөх нь /агаар дахь ялгаруулалтын жишээ дээр/ бүтээлээр шалгарч 1 дүгээр байр эзэлсэн статистикч Ц.Тэгшжаргалыг 3.000.000 /гурван сая/ төгрөг, “Монгол Улсын эдийн засгийн эмзэг байдлын үнэлгээ, түүний арга зүйг нэвтрүүлэх боломж” бүтээлээр 2 дугаар байр эзэлсэн статистикч Ю.Батзоригтыг 2.000.000 /хоёр сая/ төгрөг, “Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн эдийн засагт үзүүлж буй нөлөө” бүтээлээр 3 дугаар байр эзэлсэн статистикч О.Норовсамбууг 1.000.000 /нэг сая/ төгрөг, “Хэрэглээний үнийн индекс дэх жингийн өөрчлөлтийн нөлөөлөл” бүтээлээр тусгай байр эзэлсэн статистикч Д.Батсүх, “Хүн ам өсөлт, түүнд нөлөөлж буй хүчин зүйл” бүтээлээр Говь-Алтай аймгийн статистикийн хэлтсийн мэргэжилтэн Г.Цэрэнлхам нарыг тус бүр 500.000 /таван зуун мянга/ төгрөгөөр тус тус шагнасугай.

2. Уралдаанд байр эзэлсэн бүтээлд олгох мөнгөн шагнал болох 7.000.000 /долоон сая/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Тамгын газрын Санхүүгийн хэлтэс /Д.Батсүх/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ч.ЦЭВЭГДОРЖ

000875



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/92

Улаанбаатар хот

Комисс байгуулах тухай

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Статистикийн албаны 95 жилийн ойг угтан албан хаагчдын дунд зохион байгуулж буй эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсугай.


Комиссын дарга	А.Дэмбэрэл	Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газрын дарга
Гишүүд	Б.Энх-Амгалан	Монгол Улсын Их Сургуулийн Ахисан түвшний сургуулийн бодлогын газрын дарга
	М.Оюунжаргал	Эдийн засгийн статистикийн газрын ахлах статистикч
	Ц.Дулмаа	Хүн ам нийгмийн статистикийн газрын статистикч
	Г.Батбуян	Тамгын газрын Захиргаа хүний нөөцийн хэлтсийн референт
	Д.Лхагвацэрэн	Мэдээллийн технологийн газрын референт
Нарийн бичгийн дарга	Ч.Тунгалаг	Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газрын статистикч

2. Эрдэм шинжилгээний хуралд албан хаагчдийг идэвхтэй оролцуулахыг газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийг шалгаруулж, 2019 оны 10 дугаар сарын 31-ний дотор Үндэсний статистикийн хорооны удирдлагад танилцуулахыг комиссын дарга /А.Дэмбэрэл/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Ч.Цэвэгдорж/-т даалгасугай.


ДАРГА



А.АРИУНЗАЯА

000226

ҮСХ-НЫ ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА



**МОНГОЛ УЛСАД СТАТИСТИКИЙН АЛБА ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ
95 ЖИЛИЙН ОЙГ УГТАН ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Монгол Улсын статистикийн хөгжлийн өнөөгийн байдалд дүгнэлт хийж, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон шинэлэг санаа дэвшүүлсэн, шинжлэх ухааны үндэслэлтэй, онолын болон практик судалгаанд тулгуурласан шинжилгээ судалгааны ажлыг бичиж, хэлэлцүүлэхэд оршино.

Хоёр. Шинжилгээ судалгааны ажлын ерөнхий чиглэл

- Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн шинжилгээ
- Хүн ам, хөдөлмөр эрхлэлт, ядуурал, нийгмийн салбарын үзүүлэлтүүд, түүнд нөлөөлж буй хүчин зүйл
- Тогтвортой хөгжлийн зорилгын үзүүлэлтүүдийг тооцох арга зүй (одоогоор аргачлал нь байгаа боловч мэдээллийн эх үүсвэр тодорхойгүй, гаргах боломжтой 80 үзүүлэлтийн хувьд)
- Статистикт уламжлалт бус мэдээллийг ашиглах нь (big data)

Гурав. Хамрах хүрээ

Үндэсний статистикийн хорооны албан хаагчид

Дөрөв. Шалгаруулалтын зарчим, харгалзах үзүүлэлт:

Бүтээлийг үнэлж дүгнэн шалгаруулахад үндсэн 5 шаардлагыг голлон харгалзаж үзнэ. Бүтээлд тавигдах үндсэн 5 шаардлагад харгалзах гол үзүүлэлтүүдийг сонгож, үзүүлэлт бүр харгалзах оноог өгч үнэлнэ. Үзүүлэлт бүр харгалзах оноо нь ач холбогдлын түвшнээр харилцан адилгүй байна. Үүнд:

Шалгуур үзүүлэлт	Оноо
Сэдвийг сонгосон байдал, ач холбогдол (тулгамдаж буй асуудлыг дэвшүүлсэн эсэх)	0-15
Онол, арга зүй, олон улсын стандарт зөвлөмжийн ашиглалт	0-25
Эдийн засгийн онол, статистикийн судалгаа шинжилгээний арга техник, орчин үеийн програм хангамжийн ашиглалт	0-30
Судалгаанд шаардлагатай үзүүлэлт, динамик мэдээллийн ашиглалт, хүчин зүйлийн нөлөөллийг тооцож, цаашдын чиг хандлагыг тодорхойлсон байдал	0-10
Дүгнэлт, дэвшүүлсэн зөвлөмжийн чанар, бодит байдал	0-20

Шалгаруулах бүрэлдэхүүн бүтээлийг нарийвчлан судалж, дээр дурдсан оноог өгч, нийт гишүүдийн үнэлгээний арифметик дунджаар нэгдсэн үнэлгээг гаргана.

Тав. Шалгаруулалтын үе шат

Эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааны 2 үе шаттайгаар шалгаруулна.

1-р үе шат: Уралдааныг шалгаруулах бүрэлдэхүүн 2019 оны 10 дугаар сарын 23-нд ирүүлсэн нийт бүтээлээс 5 бүтээлийг сонгон шалгаруулж, илтгэгчдэд 10 дугаар сарын 28-нд мэдээлнэ.

2-р үе шат: 2019 оны 10 дугаар сарын 31-нд 1-р шатнаас шалгарсан 5 илтгэлүүдийг хэлэлцүүлэн 1, 2, 3, тусгай байр 2 илтгэлийг тодруулна.


Зургаа. Шагнал урамшуулал

Тэргүүн байр	1	Өргөмжлөл, 3 000 000 төгрөг
Дэд байр	1	Өргөмжлөл, 2 000 000 төгрөг
Гутгаар байр	1	Өргөмжлөл, 1 000 000 төгрөг
Тусгай байр	2	Өргөмжлөл, 500 000 төгрөг

Ирүүлсэн бүх шинжилгээ судалгааны ажлыг нэгтгэж, эмхэтгэн хэвлүүлнэ.

Долоо. Хүлээн авах хаяг, утас

Шинжилгээ судалгааны ажлыг 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр 17 цаг 30 минут хүртэл цаасаар 203 тоотод, цахимаар norovsambuу_о@nso.mn хаягаар хүлээн авна. Хуралтай холбоотой асуудлаар 99159840, 51-262903 дугаарын утсаар холбогдоно уу.

Хянасан:  А.Дэмбэрэл ҮТШСГ-ын дарга

Д.Батсүх ТГ-ын Санхүүгийн хэлтсийн дарга

Боловсруулсан:

 О.Норовсамбуу ҮТШСГ-ын статистикч

--oOo--